



ЦУС СЭЛБЭЛТ СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ

2021 оны 01 сарын 11 өдөр

Дугаар А/03

Улаанбаатар хот

Төвийн үйл ажиллагааны бэлэн байдлыг хангах зарим арга хэмжээний тухай

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.3 дахь заалт, 35 дугаар зүйлийн 35.2 дахь хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.2, 20.2.8 дахь заалт, Засгийн газрын 2020 оны 178 дугаар тогтоол, Эрүүл мэндийн сайдын 2020 оны А/520 дугаар тушаал, Онцгой байдлын ерөнхий газрын даргын “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээдийг ажлын тусгай горимд шилжүүлэх, ажиллах журам” баталсан 2018 оны А/274 дүгээр тушаал, Эрүүл мэндийн сайдын 2020 оны 12 дугаар сарын 29-ний өдрийн 30 дугаар албан даалгавар, Улсын онцгой комиссын 2020 оны 12 дугаар сарын 24-ний 3785 тоот албан бичиг, Эрүүл мэндийн яамны 2020 оны 12 дугаар сарын 28-ны 7/5861 тоот албан бичгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Коронавируст халдвар (Ковид-19)-ын цар тахалтай тэмцэх хариу арга хэмжээг эрчимжүүлэх, урьдчилан сэргийлэх, Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас гаргасан зөвлөмжийг хэрэгжүүлэх, үйл ажиллагааны тасралтгүй байдлыг хангах зорилгоор Сувилахуй, үйлчилгээний алба, Донор зохион байгуулалтын тасаг, Нэгдсэн лабораторийн тасаг, Үйлдвэрлэлийн тасаг, Инженер, техникийн тасгийн эмнэлгийн мэргэжилтэн, ажилтнуудыг 2021 оны 1 дүгээр сарын 19-ний өдрөөс (Ковид-19) цар тахалын вакцинжуулалтад хамрагдаж дуусах хүртэл хугацаагаар 1 /ажлын байранд ажиллах/ :0,5 /гэрээсээ ажиллах/ харьцаагаар бэлэн байдал хангуулан /шаардлагатай тохиолдол ирж ажиллах бэлтгэлтэйгээр/ гэрээсээ ажиллах зохицуулалт хийхийг алба, тасгийн дарга, эрхлэгч нарт зөвшөөрсүгэй.

2. Алба, тасгуудын ажлын тусгай горимд ажиллах үлгэрчилсэн харьцааг 1 дүгээр, бэлэн байдал ханган гэрээсээ үүрэг гүйцэтгэх горимоор ажиллах ажилтнуудын гүйцэтгэх ажил, үүрэг, түүний биелэлтийг тайлагнах хүснэгтийг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

D:\bichig hereg\ALBAN BICHIG\Tushaal\tushaal-2021\A.docx

080426

3. Коронавируст халдвар (COVID-19)-ын цар тахалтай тэмцэх хариу арга хэмжээтэй холбогдуулан гэрээсээ ажиллах үүрэг гүйцэтгэсэн ажилтны тайланг цалин, урамшуулал олгох үзүүлэлтэд хамруулан дүгнэж, 7 хоног бүр Хүний нөөцийн менежер, хуулийн зөвлөх /Я.Тогтохням/-д ирүүлж байх, бэлэн байдал ханган гэрээсээ ажиллах горимоор үүрэг гүйцэтгэх үедээ бэлэн байдал хангаагүй /утас холбогдоогүй, дуудах үед ирээгүй, зөвшөөрөлгүй нийслэлээс гарсан, алба, тасгийн дарга, эрхлэгчийн өгсөн ажил, үүргийг биелүүлээгүй/ ажилтнуудад сахилгын шийтгэл ногдуулах санал боловсруулан танилцуулахыг Сувилахуй, үйлчилгээний алба /Б.Өнөрцэцэг/, Донор зохион байгуулалтын тасаг /Ч.Тунгалаг/, Нэгдсэн лабораторийн тасаг /М.Цэрэндэжид/, Үйлдвэрлэлийн тасаг /Н.Халиун/, Инженер, техникийн тасаг /Б.Энхмэнд/ нарт, ажилтны цалин, урамшуулал, хариуцлага ногдуулах шийдвэрийн төслийг алба, тасгийн дарга, эрхлэгч нарын дүгнэлт, ажилтны тайланг үндэслэн танилцуулж, тооцохыг Хүний нөөцийн менежер, хуулийн зөвлөх /Я.Тогтохням/-д тус тус даалгасугай.

4. Энэ тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, маркетингийн алба /Ч.Батболд/-д даалгасугай.

ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ



Н.ЭРДЭНЭБАЯР



ЦССҮТ-ийн Ерөнхий захирлын
2021 оны 04 сарын 11-ний
өдрийн АХЗ тушаалын
1 дүгээр хавсралт

1118266548

АЛБА, ТАСГУУДЫН АЖЛЫН ТУСГАЙ ГОРИМД АЖИЛЛАХ ҮЛГЭРЧИЛСЭН ХУВААРЬ

№	Алба, тасгийн нэр	Нийт ажилтны тоо	Үүнээс		Ажлын байранд үүрэг гүйцэтгэх, бэлэн байдал ханган гэрээсээ үүрэг гүйцэтгэх ажилтны харьцаа	
			Эмч удирдлага /инженер/	Тусгай мэргэжилтэн /бусад ажилтан/	Эмч	Тусгай мэргэжилтэн /бусад ажилтан/
1	Сувилахуй, үйлчилгээний алба	8	1	7		6:1
2	Донор зохион байгуулалтын тасаг	17	5	12	3:2	6:6
3	Нэгдсэн лабораторийн тасаг	9	3	6	2:1	4:2
4	Үйлдвэрлэлийн тасаг	13	2	11	1:1	4:3 /ээлжээр ажиллах сувилагч нарт хамаарахгүй/
5	Инженер, техникийн тасаг	6	2	4	1:1	1:1

Жич: Дээрх ажлын байранд болон гэрээсээ ажиллах горимоор ажиллагсдын харьцааг үүссэн нөхцөл байдал, хэрэгжүүлэх хариу арга хэмжээтэй уялдуулан алба, тасгийн дарга, эрхлэгч өөрчлөн тогтоож болно.



ЦССҮТ-ийн Ерөнхий захирлын
2021 оны 07 сарын 11-ний
өдрийн А/СЗ тушаалын
2 дугаар хавсралт

БЭЛЭН БАЙДАЛ ХАНГАН ГЭРЭЭСЭЭ ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭХ ГОРИМООР АЖИЛЛАХ
АЖИЛТНЫ ГҮЙЦЭТГЭХ ҮҮРЭГ, ТҮҮНИЙ БИЕЛЭЛТИЙГ ТАЙЛАГНАХ ХҮСНЭГТ

..... Овог, нэр, нэгжийн нэр, албан тушаал

Бэлэн байдал ханган гэрээсээ ажиллах горимд хамрагдах хугацаа: 2021 оны сарын-ээс сарын-ний өдөр

№	Алба, тасгийн дарга, эрхлэгчийн өгсөн үүрэг	Гүйцэтгэх хугацаа	Биелэлт	Алба, тасгийн дарга, эрхлэгчийн дүгнэлт
1				
2				
3				
4				

Жич: Дээрх тайланг алба, тасгийн дарга, эрхлэгчид ажлын байранд ажиллахаар ирсэн өдрөө танилцуулан дүгнүүлсэн байна.